



СУДЛААЧДЫН АНХДУГААР УУЛЗАЛТЫН ҮЕЭР ГАРСАН САНАЛУУД

Судлаачдын анхдугаар уулзалт дөрөвдүгээр сарын 25-ны Пүрэв гарагт Стратеги судалгааны хүрээлэнгийн хурлын танхимд 09:30 цагаас эхэлж, 11:30 цагт өндөрлөв.

Уулзалтыг санаачлан зохион байгуулсан Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ)-ийн ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Лакшми, ССХ-гийн захирал Б.Ганбат нар хурлыг нээж үг хэллээ. Хуралд төр, ТББ, хувийн хэвшлийн 20 орчим байгууллагын төлөөлөл оролцсон бөгөөд өөрсдийгөө товч танилцуулав.

ЭЗБӨЧСТ-ийн менежер И.Одончимэг төвийн үйл ажиллагаа, боловсруулан гаргадаг өрсөлдөх чадварын тайлангуудынхаа талаар товч танилцуулсан бол Азийн хөгжлийн банкны эдийн засагч Л.Амар “Баялгийн хараал ба төсвийн бодлого” сэдвээр илтгэл тавив.

Байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах, цаашдаа сар бүр зохион байгуулахаар төлөвлөж буй “Монголын судлаачдын уулзалт”-ын үр ашгийг яаж нэмэгдүүлэх талаар оролцогчид санал бодлоо хуваалцсан нь арга хэмжээний чухал үр дүн байсан юм. Тэдгээр саналыг тоймлон хүргэж байна:

Л.Амар, АХБ-ны эдийн засагч:

Дараа дараагийн уулзалтын үеэр оролцогчид төлөөлж ирсэн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц зэргээ 5 минутын дотор, 2-3 слайдад багтаан товч танилцуулж байвал зүгээр юм байна.

УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Ц.Норовдондог:

УИХ-ын Тамгын газраас санаачлаад 5 дугаар сарын 20-нд судалгааны байгууллагуудын уулзалт зохион байгуулах гэж байгаа. Үүнийг Монголын судлаачдын энэхүү уулзалтын үргэлжлэл болгон хийх тухай ярьж болно.

Шийдвэр гаргах түвшинд судалгааны бүтээлүүдийг яаж хүргэх вэ гэдэг чухал. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд бид судалгааны бусад байгууллагатай хамтын ажиллагаа тогтоохыг эртнээс төлөвлөж байгаа. Судалгаагаа эргэлтэд оруулахын тулд бид хамтран ажиллах хэрэгтэй байна. Судалгааны брокер, мэдээллийн менежментэд анхаарах цаг болсон. Бид өөрсдөө судалгаагаа хийгээд, энэ тал дээр ажиллая гэхээр хүн хүч, цаг зав хүрэлцэхгүй байгаа учраас Та бүхний хүчийг ашиглах хэрэгтэй байна. Манай Судалгаа, шинжилгээний хэлтэс 13 судлаач, нэг ахлахтай үйл ажиллагаа явуулдаг.

Б.Ганбат, ССХ-гийн захирал:

Гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын чиглэлээр ийм уулзалт тогтмол зохион байгуулж ирсэн сүүлийн 2 жилийн туршлагаасаа үзэхэд хэдэн зүйлд анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Мэдээллээ байнга солилцож байх
2. Судалгааныхаа сэдвүүдийг бусдадаа танилцуулж байх
3. Төлөвлөсөн хурал, семинарынхаа талаар мэдээлж байх



Энэ бүх мэдээллийг хүргэж байхын тулд судлаачдын и-мэйл жагсаалт үүсгэх хэрэгтэй. Иймэрхүү ажлыг нийлээд хийе гэхээр мөнгө дутдаг зовлон бий. Харин координац хийх тал дээр бид туршлагатай учраас тусалж болно. Гэхдээ энэ нь илүү эдийн засгийн судлаачдад хамааралтай болохоор мэргэжлийн талаасаа ЭЗБӨЧСТ координац хийгээд явахад болох байх гэж бодож байна. Бидний зүгээс хурлын танхим гаргаж өгөх байдлаар цаашдаа хамтраад явж бас болно.

Л.Амар:

Энэ уулзалт үр дүнтэй болж байгаад сэтгэл өндөр байна. АХБ нь Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтраад судлаачдыг дэмжих төсөл хэрэгжүүлж байгаа. Өнөөдрийн энэ уулзалтыг цаашдаа тогтмол зохион байгуулах нь үр ашигтай, хэрэгцээтэй гэж бодож байна. Тиймээс санхүүжилтийн ямар нэгэн асуудал байвал АХБ-наас тодорхой дэмжлэг үзүүлэх боломж бий.

Б.Мөнхсоёл, Нээлттэй нийгэм форум:

Нээлттэй нийгэм форум судалгаагаа өөрсдөө хийхийн зэрэгцээ гаднын аутсорсинг ашигладаг. Цаашдаа судалгааны байгууллагууд, судлаачид хоорондоо танилцаж, хамтарч судалгаа хийж ажиллах боломжтой.

ЭЗХЯ-ны төлөөлөл:

Судлаачдыг чадавхжуулах чиглэлд үйл ажиллагаа явуулах нь чухал болов уу.

Доктор, профессор Л.Цэдэндамбаа, ҮХХ, Эрдэмтэн нарийн бичгийн дарга:

Азийн барууд дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулах замаар хурдтай хөгжсөн байдаг. Монголд ийм хөтөлбөр байхгүй учраас намуудын мөрийн хөтөлбөрт хөтлөгдөөд яваад байна. Япон, Өмнөд Солонгос зэрэг орны туршлагаас үзэхэд олон 5 жилийн хөтөлбөрөө амжилттай төлөвлөж, хэрэгжүүлж ирсэн. Тиймээс бид урт, дунд хугацааны хөгжлийн бодлогоо судалгааны дагуу тодорхойлох ёстой. Энэ тал дээр Монголын судлаачид бид хамтарч ажиллах хэрэгтэй.

Б.Энхбайгаль, ҮХХ-гийн захирал:

Судлаачдын бүтээл, танилцуулга зэргийг багтаасан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, цахим хуудас ажиллуулах хэрэгтэй. Тэрхүү мэдээллийн санд дотоод, гадаадын хүмүүс нэвтэрч хэрэгцээт мэдээллээ авч болдог байвал зүгээр. Энэ тал дээр ҮХХ хамтарч ажиллаж болно.